


**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД**



**Х.НЯМБААТАР**

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Зургаа дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.” гэж тус тус тусгасан.

**1.2.Практик шаардлага**

1.Монгол Улсад авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн хэдий ч Авлигын индексийн үзүүлэлт 2016 оноос тогтмол, огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Тухайлбал, Монгол Улс авлигын индексийн дүнгээр 2015 онд 39 оноо авч 72 дугаар байр, 2016 онд 38 оноо авч 87 дугаар байр, 2017 онд 36 оноо авч 103 дугаар байр, 2018 онд 37 оноо авч 93 дугаар байр, 2019 онд 35 оноо авч 106 дугаар байр, 2020 онд 35 оноо авч 111 дүгээр байр, 2021 онд 35 оноо авч 110 дугаар байрт эрэмблэгдсэн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт 11 төрлийн авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд статистикийг эдгээр төрлөөр авч үзэхэд 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан Хахууль авах, өгөх гэмт хэрэг нийт авлигын хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2017 онд 658, 2018 онд 858, 2019 онд 894, 2020 онд 1020, 2021 онд 1144, шалгасан эрүүгийн хэрэг 2017 онд 427, 2018 онд 1138, 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг 2017 онд 44, 2018 онд 84, 2019 онд 68, 2020 онд 114, 2021 онд 160 байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг бүгд өсөж байгааг харуулж байна.

Иймд Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь адил хэмжээний ял хариуцлага оногдуулахаар заасан байгааг ялгамжтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, Хахууль авах гэмт хэргийн субъектийг нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хамаарахаар ялган тодорхойлох, энэ бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах зэрэг өөрчлөлтийг хийж авлигатай тэмцэх төрийн бодлогыг чангатгах шаардлагатай байна.

Үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, Авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангах бодлогыг баримтлан холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

2. Мөнгө угаах болон татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн онцлог, олон улсын байгууллагаас Монгол Улсад өгсөн зөвлөмжийг харгалзан эдгээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг анхаарах, мөн халдашгүй бүрэн эрхээр “халхавчлан” хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

3. Гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

4. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад “Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно.” гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцүүлэн ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцохтой холбогдсон нэмэлтийг Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт оруулах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Ийнхүү Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт орж байгаатай холбогдуулан энэхүү гэмт хэргийг тагнуулын байгууллага мөрдөн шалгах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хуульчлах шаардлага тулгараад байна.

Дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг боловсруулна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

-Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэргийн хохирлыг хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан шинэлэн тогтоох, хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолох, Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тусгах, тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг хорин жил хүртэл хугацаагаар оногдуулах, өршөөл, уучлал үзүүлэхгүй байх гэмт хэрэгт мөнгө угаах, авлигын гэмт хэргийг хамааруулах нэмэлтийг тусгав.

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлэгт Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний ял хариуцлага адил хэмжээтэй оногдуулахаар заасан давхардал, зөрчлийг арилгаж ялгамжтай байхаар өөрчлөх, энэ бүлгийн гэмт хэрэгт оногдуулах санкцийн торгох ялыг нэмэгдүүлэх, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасах, хорих ялыг нэмэгдүүлэх, үүнтэй уялдуулан нийтийн албанд ажиллах эрх хасах ялыг 2-8 жилийн хугацаагаар, эсхүл 20 жил хүртэл хугацаагаар хасах зэрэг өөрчлөлтийг тусгана.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулна.

-Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахаар уриалсан, санаачилсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн үйлдлийг Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт заасан Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцож хуульчилна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ард нийтийн санал асуулга явуулах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг явуулах харьяаллыг Тагнуулын байгууллагад хамааруулах өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүгийн хуулийн холбогдох бүлэг, зүйлд заасан гэмт хэргийн гаралт буурах, авлига, албан тушаалтантай тэмцэх төрийн бодлого чангарч, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчим улам бүр баталгаажна гэж үзэж байна.

Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх ард нийтийн санал явуулахыг олон нийтэд уриалсан, санаачилсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн үйлдлийг хориглож, гэмт хэрэгт тооцсоноор Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал баталгаажна.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---